

А.И.Востриков

ТӨВД ХЭЛЭЭРХИ ТҮҮХИЙН ЗОХИОЛ



**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ**

МОНГОЛ ХЭЛ, ХЭЛШИНЖЛЭЛИЙН ТЭНХИМ

А.И.Востриков

**ТӨВД ХЭЛЭЭРХИ
ТҮҮХИЙН ЗОХИОЛ**

хянан зассан хоёр дахь хэвлэл

Орос хэлнээс орчуулсан
Доржсүрэнгийн Бүрнээ

Хянан тохиолдуулсан
Дамбийжанцангийн Энхтөр

Улаанбаатар
2015

Төвд хэлээрхи түүх бичлэгийн сонгодог судалгааны нэг болох А.И.Востриковын бичсэн “Тибетская историческая литература” хэмээх бүтээлийн монгол орчуулгыг толилуулж байна. Тус зохиолд төвд хэлээрхи түүхэн сурвалж бичгүүдийг дотор нь он дарааллын бичиг (лоржүй), хаадын ургийн бичиг (жалрав), сүм хийдийн он дарааллын бичиг (данрав), хутагт хувилгаадын түүх (түнрав), намтар, шашны он дарааллын зохиол (данзий), шашны номлол сургаалын түүх (чойнжун), сонссон тэмдэглэл (сан-ег) гэх зэрэг төрөл зүйлээр нь нарийн ангилан хувааж, тухайн зохиолын агуулга бүтэц, дэлхий дахинд судалсан тоймыг авч үзжээ. Ингэхдээ өмнөх судалгаанд гарсан алдаа мадагтай, эндүү ташаа зүйлийг залруулсан байна.

Тус зохиолд 700 орчим зүүлт тайлбар болон төвдийн тооллыг европын тоололд шилжүүлэх хүснэгт, зохиолд гарч буй төвд болон кирил бичгээр бичсэн оноосон нэр, газар орон, сүм хийд, тогтсон таалал тэргүүтний нэрийн хэлхээс, дэлгэрэнгүй ном зүй дагалдуулсан нь уг зохиолыг үзэж ашиглах хүмүүст чухал хэрэглэгдэхүүн болж байгаа юм. Нэн ялангуяа төвд хэлээр түүхийн сэдвээр бүтээлээ туурвиж байсан Сүмба хамбо Ишбалжир, Цахар гэвш Лувсанчүлтэм, Цэмбэл гүүш, Зая бандид Лувсанпэрэнлэй тэргүүтэй монголын нэрт эрдэмтэн мэргэдийн зохиол бүтээлийг ч судалгааны тоймтой нь нарийвчлан авч үзсэн байгаа тул дундад зууны монголын төвд хэлээр уламжилж ирсэн түүх бичлэгийг судлах, нэн ялангуяа төвдийн түүх бичлэгтэй харьцуулан, залгамж холбоог судлахад чухал гарын авлага болох юм.

ГАРЧИГ

Орчуулагчийн үг.....	5
Зохиогчийн үг	9
Оршил	11
 Нэгдүгээр бүлэг. Төвдийн нэн эртний түүхийн зохиол.	19
 Хоёрдугаар бүлэг. Сангийн ном	24
а) “Гачэм- гахолма”	24
б) “Бадмагатаг”	25
в) “Тан-ег сэргпрэн”	35
г) “Гатан-дэн-а”	38
д) “Манигамбум”	40
 Гуравдугаар бүлэг. Төвд хэлээрхи түүхийн зохиолын ерөнхий төрөл зүйл	46
§ 1. Ерөнхий тэмдэглэл	46
§ 2. Он дарааллын бичиг	49
§ 3. Гэрийн үеийн бичгийн үндэстэй түүхэн зохиолууд: овог ба ургийн он дарааллын бичгүүд	50
§ 4. Сүм хийдийн он дараалсан бичиг	66
§ 5. Хутагт хувилгаадын түүх	68
§ 6. Шашны он дарааллын зохиол	72
§ 7. Шашин буюу номлол сургаалын түүх	82
§ 8. Намтар зохиол	102
§ 9. “Олсон” буюу “сонссон” тэмдэглэл	108
§ 10. Лавлах бичгүүд	112
§ 11. Бусад сэдвээр бичсэн зохиол	114
 Дөрөвдүгээр бүлэг. Төвд Ганжуур, Данжуурын түүх-ном зүйн тойм.....	115

Тавдугаар бүлэг. Түүх-газар зүйн зохиол	122
Дүгнэлт	133
Зүүлт болон нэмэлт тайлбар	134
Төвдийн тооллыг европын тоололд шилжүүлэх хүснэгт	318
Төгсгөлийн үг	321
Санскрит үгийн хэлхээс	324
Кирил үгийн хэлхээс	325
Төвд үгийн хэлхээс.....	335
Ном зүй	364
Товчилсон үгийн жагсаалт	383

Орчуулагчийн үг

Андрей Иванович Востриковын (1904-1937) “Төвд хэлээрхи түүхийн зохиол” хэмээх нэгэн сэдэвт зохиол 1962, 2007 онд орос хэлээр, 1970, 1994 онд англи хэлээр тус тус хэвлэгдэн гарчээ. Төвд хэлээрхи түүх бичлэгийн судлалд дорвитой хувь нэмэр оруулсан энэхүү бүтээлийг бичсэн зохиогч А.И.Востриков ОХУ-ын Петербургийн Их сургуулийг төгсчээ. Түүний багш нь оросын нэртэй дорно дахины судлаач Ф.И.Щербатской байсан юм. Тэр бээр багшийнхаа удирдлагаар санскрит, төвд хэл болон буддын гүн ухааныг судлахын зэрэгцээ Б.Я.Владимирцовын удирдлагаар монгол хэл сурч байв. А.И.Востриков 1925 онд эрдэм шинжилгээний ажилтан болжээ. 1926 онд Ленинградын Их сургуулийн Өрнө болон Дорно дахины хэл, утга зохиолын харьцуулсан түүх судлалын хүрээлэнгийн аспирантурт элсэн орж, Азийн музейд давхар ажиллах болсон байна. 1928-1929 онд Буддын соёлын хүрээлэнд ажиллав. 1930 онд ЗХУ-ын Шинжлэх ухааны академийн Дорно дахины хүрээлэн байгуулагдаж түүнд Азийн музей болон Буддын соёлын хүрээлэн харьяалагдах болоход А.И.Востриков сан хадгалагч болон эрдэм шинжилгээний ахлах ажилтны орон тоон дээр ажиллах болжээ. 1927-1932 онд Буриадын Агын дацанд судалгаа хийж, төвд хэлээрхи арвин номыг цуглуулсан байна. Түүний эрдэм судлалын ажлыг үнэлж, 1935 оны нэг сарын 15-д утга зохиол судлалын докторын цол олгожээ. Удаан хугацааны туршид тэр бээр Оросын ШУА-ийн Дорно дахины хүрээлэнгийн Энэтхэг-Төвд танхимын эрдэмтэн нарийн бичгийн даргын үүрэгт ажлыг гүйцэтгэж байв. 1937 онд тус танхимаас Төвдийн бүлгийг бие даасан танхим болгоход ахлагчаар нь томилогдон ажилласан боловч удалгүй мөн онд хэлмэгдүүлэлтийн давалгаанд өртөж, зуурдаар нас баржээ. Хожим түүнийг цагаатгасан байна. Тэр бээр богино наслахдаа их зүйлийг хийсэн боловч түүнийг амьд сэрүүн байхад нь ч, нас барснаас нь хойш ч ихэнхи бүтээлийг нь тухайн үеийн үзэл суртлын нөлөөнөөс болоод хэвлэхгүй удсаар 1962 онд л анх хэвлэжээ.

1962 онд орос хэлээр хэвлэгдсэн “Төвд хэлээрхи түүхийн зохиол”-ын өмнөх үгийг бүрэн эхээр нь орчуулан толилуулж байна.

Профессор Андрей Иванович Востриков бол оросын дорно дахины судлалын гарамгай эрдэмтдийн нэг байв. Тэр бээр Төвд болон Энэтхэгийн түүх, гүн ухааны судлалд ихээхэн хувь нэмэр оруулсан хүн юм.

1931 онд А.И. Востриков “Dharmakirti-гийн гүн ухааны үзлийн тухай” хэмээх бүтээлээ хэвлэлд бэлдсэн болно. 1933 онд академич Ф.И.Щербатской болон академич С.Ф.Ольденбург, профессор Е.Е.Обермиллер, эрдэм шинжилгээний ажилтан Б.В.Семичовын хамт санскрит хэлнээс Каутильегийн улс төр-эдийн засгийн зохиол болох “Артхашастра”-г орчуулж, тус зохиолын нэр томъёоны толийг хийв. 1934 онд А.И. Востриков “Logical works of Vasubandhu” хэмээх өгүүлээ хэвлүүлжээ. Дараа жил нь өөртөө байсан бүх сурвалж бичгийг ашиглан “Logic of Vasubandhu” хэмээх нэгэн сэдэвт зохиолоо бичиж тус сэдвийн хүрээнд байсан асуудлыг бүрэн шийдвэрлэж чадсан юм. 1934 онд “Indian historical quaterly” (Vol.XI, N1, March, 1935) хэмээх сэтгүүлд “The Nyāyavārtika of Uddyotakara and the Vādanyāya of Dharmakirti” хэмээх өгүүлэл нь хэвлэгдэв.

Профессор А.И.Востриков амьдралынхаа сүүлийн жилүүдэд “Калачакра” хэмээх эртний энэтхэгийн буддын гүн ухааны дурсгалыг судлаж орчуулж байв. Тэр бээр хоёр гар бичмэлийн нэгтгэсэн (“Калачакра”-гийн лондонгийн болон өмнөд хэвлэлийн эх, тус эхийг профессор И.П.Минаев Энэтхэгээс авчирчээ) эх болон төвд орчуулгыг хэвлэлд бэлтгэж байсан боловч орос хэлнээ орчуулах, тайлбарлах ажлаа дуусгаж амжаагүй билээ.

А.И. Востриков төвд судлалд ихээхэн анхаарал тавьж байв. Тэр бээр шинжлэх ухааны үндэстэй төвд хэлний зүйг зохиоход оролцож байсан ч дуусгаж амжаагүй бөгөөд 1941 онд уг ажлыг Ф.И.Щербатской гүйцээж дуусгасан болно. А.И. Востриков төвд хэлээрхи түүхийн зохиолын асуудлыг илүү сонирхож байсан юм. 1934 онд “Библиография Востока” (№2-4) сэтгүүлд “Библиография тибетской литературы” хэмээх түүний өгүүлэл хэвлэгдсэн бөгөөд тэр бээр Ван Манены “Contribution to the Bibliography of Tibet” хэмээх өгүүллийг шүүмжлэн бичсэнээс гадна төвд хэлээрхи түүхийн зохиолын талаарх шинэ мэдээ баримтыг дурдсан байна. 1936 онд тус өгүүлэл англи хэлээр хэвлэгдэн гарсан (Some corrections and critical remarks on Dr.J.van Manen’s Contribution to the bibliography of Tibet,- “Bulletin of the School of Oriental Studies”, London, vol.VIII, 1935, pp.51-76) ба дэлхий дахины төвд судлаачдын

анхаарлыг маш ихээр татсан билээ.

А.И.Востриковын бусад бүтээлийн дотроос “Летопись баргузинских бурят” (Труды Института востоковедения, Материалы по истории бурято-монголов, I, М. -Л., 1935) болон “С.Ф.Ольденбург и изучение Тибета” (Записки Института востоковедения АН СССР, т. IV. М. -Л., 1935) хэмээх өгүүллгийг дурдах хэрэгтэй. Сүүлийн өгүүлэлд Орос дахь Төвд судлалын түүх болон ЗХУ-ын ШУА-ийн Азийн улс түмний хүрээлэнгийн Ленинградын салбарын дэлхийд томоохонд тооцогддог төвд номын хөмрөгийн гар бичмэл болон барын номыг хэрхэн цуглуулсан түүхийн талаар бичжээ.

Энэхүү хэвлүүлж буй “Төвд хэлээрхи түүхийн зохиол” хэмээх нэгэн сэдэвт зохиол бол төвд утга зохиолын олон төрөл зүйлийг хамарсан, тун бага судлагдсан зохиолыг жигдлэн журамлах болон тодорхойлох талаар хийж амжсан А.И. Востриковын ажлын үр дүн болно. Тус зохиолдоо зориулж төвд тооллыг европын тоололд шилжүүлэх тусгай хүснэгтийг хавсаргасан юм¹.

А.И.Востриковын “Төвд хэлээрхи түүхийн зохиол”-ыг 2007 онд эрхлэн хэвлүүлсэн оросын залуу эрдэмтэн А.В.Зорин зохиогчийн намтартай холбоотой шинэ баримтыг олж мэдээлснээс гадна түүний бүтээлийн дотор дурдагдаж буй ном судрын хадгалалтын талаар 200 гаруй зүүлт хийж, хятад, монгол нэрийн хэлхээс болон 2006 оноос хойш төвд утга зохиол судлалаар гарсан бүтээлийн тоймыг хавсаргасан байна.

А.И. Востриковын 1937 онд бичсэн энэхүү сонгодог бүтээлээс хойш багагүй хугацаа өнгөрсөн боловч түүний бүтээл үнэ цэнэтэй хэвээрээ байгаа билээ. Тиймээс ч орчин үед төвдийн түүх бичлэгийн талаар дорвитой бүтээл туурвисан нэрт төвд судлаач Д.Мартин тус бүтээлийг дэлхийн шинжлэх ухааны сонгодог бүтээл хэвээрээ байгааг нь онцлон тэмдэглэжээ².

А.И. Востриковын судалгаанд монголчуудын төвд хэлээр бичсэн олон бүтээлийн талаар дурдсан байна. Тиймээс тус судалгаа төвд хэлээрхи түүхийн зохиолын судлалд чухал хувь нэмэр оруулахаас гадна төвдийн түүхийн зохиол монголын

¹ D.Martin, Tibetan Histories: a Bibliography of Tibetan-language Historical Works. London: Serindia, 1997.

² А.И.Востриков, Тибетская историческая литература, составление, комментарии, А.В.Зорина, Санкт-Петербург, 2007.

дундад зууны түүх бичлэгт үзүүлсэн нөлөө, төвд монголын утга зохиолын харилцаа холбоо, монголын төвд хэлээрхи түүхийн зохиолыг судлахад чухал гарын авлага болох юм.

А.И. Востриковын зохиолыг монгол уншигчиддаа зориулж, орос хэлнээс орчуулан толилуулж байна. Бид 1962, 2007 оны орос хэвлэлийн оршилд бүхий зохиогчийн намтартай холбоотой мэдээ баримтыг товчлон оруулж, нэмэлт ном зүйг бүрэн эхээр нь хавсаргав.

Уншигч таны мэлмий соргог, өлмий бат орших болтугай.

Зохиогчийн үг

“Төвд хэлээрхи түүхийн зохиол” хэмээх тэмдэглэлийнхээ үндсэн санааг миний бие 1935 оны гуравдугаар сард хуралдсан ЗХУ-ын Шинжлэх ухааны академийн бүгд хуралдаан дээр танилцуулсан билээ. Тус хуралдаан дээр миний мэдээллийг анхааран сонсож, холбогдох бүх хэрэглэгдэхүүний хамт “Азийн улс түмний хүрээлэнгийн бүтээл”-д хэвлүүлэх санал гаргасан явдал анх маш товчилж хураангуйлан бичсэн өгүүлээ цаашид нэмэн дэлгэрүүлж бичих хүслийг минь төрүүлсэн юм. Миний бие Азийн улс түмний хүрээлэнгийн цуглуулгад байгаа хамгийн чухал, хамгийн сонирхолтой төвдийн түүх бичлэгийн дурсгалыг хураангуй ч атугай тоймлон өгүүлэхийг оролдсон билээ. Гэсэн ч миний нэмэн дэлгэрүүлж бичсэн тэмдэглэлийг бүрэн гүйцэд болсон гэж хэрхэвч үзэж болохгүй. Харин төвд хэлээрхи түүхийн зохиолыг судлах удиртгал төдий л болох юм.

Энэ ажлаа хэвлэлд бэлдэж байх явцад надад төвд үгийг галиглахад эргэлзэх зүйл их гарч байв. Эхлээд би төвд үгийг гагцхүү төвд цагаан толгойн үсгээр тэмдэглэвэл боломжтой гэж үзэж байв. Гэтэл ингэж хийвэл миний ажлыг төвд судлаач бус хүмүүс үзэх боломжгүй болох байсан юм. Латин үсгийн галиг хэрэглэвэл байдлыг хөнгөвчлөх боловч бас л бүрэн хангаж чадахгүй байв. Учир нь төвд үгийн бичлэг болон дуудлага хоорондоо эрс зөрөөтэй тул мэргэжлийн бус хүн бас л уншиж чадахгүй байсан юм. Зүй ёсоор бол төвд үгд лхас дуудлагын галигийг бичиж болох байв. Гэтэл энэ дуудлагыг оросын шинжлэх ухааны зохиолд өнөө хүртэл хэрэглэдэггүй учир түүнийг хэрэглэвэл олны сайн мэддэг нэрийг танигдахгүй болгож мэдэх байв. Түүнээс гадна хэрэв хэрэглэвэл нэмэлт тэмдгийг тайлбарлах шаардлага тулгарч, улмаар их зай эзэлж, бид өмнөө тавьсан гол зорилтоосоо холдох байсан юм. Тиймээс миний бие өөрийн багш академич Ф.И.Щербатскийн зөвлөснөөр манай утга зохиолд төвд үгийг монгол дуудлагаар тэмдэглэж, орос үсгийн хялбаршуулсан галиг дагалдуулдаг аргыг хэрэглэхээр шийдсэн болно. Ингэхдээ энэ дуудлагыг (зарим нэг хувилбар бий) Монгол

болон Буриадад хэрэглэдэгийг бас анхаарсан билээ. Ямарваа нэг эндүүрэл гарахаас зайлсхийж үг хэллэгийг төвдөөр тэмдэглэхийн сацуу дуудлагыг бас зэрэгцүүлэн галиглав.

Энэхүү тэмдэглэл дотор гарах ойлголтуудыг цаашид дэлгэрүүлж үзэх буюу нарийвчлан судлахад зориулж зүүлт хийсэн маань нэлээд их зай эзлэв. Тиймээс үзэж ашиглахад хялбар болгох зорилгоор тайлбарыг номынхоо төгсгөлд оруулав. Харамсалтай нь эх зохиол болон зүүлт тайлбарын харьцааг тэр бүр нарийн дэс дараатай хийж чадсангүй. Зарим зүүлт тайлбарыг үндсэн зохиолд оруулах буюу зохиолын доторхи зарим тодорхойлолтыг зүүлт тайлбарт оруулбал зохих байв. Нүсэр их ажлыг эмхэлж цэгцлэх цаг хугацаа маш давчуу байсан тул засвар хийж амжаагүй болно. Энэ дутагдлыг нөхөхөд зүүлт тайлбар уншигчдад тус дөхөм болно гэж найдаж байна.

Миний ажлыг эхнээс нь байнга анхаарч байсан Ф.И.Щербатской болон энэ ажилд минь төдийгүй хэлхээс хийхэд хүртэл өөрийн биеийг хайрлахгүй чин сэтгэлээсээ туслан зөвлөж байсан Н.П.Вострикова нарт гүн талархлаа илэрхийлэх нь зүйтэй гэж бодож байна.

1936 оны 10 сар
А.И.Востриков
Ленинград

Оршил

Бүгд Найрамдах Хятад Ард улс дахь Төвд бүс нутгийн * түүхийг шинжлэх ухааны үүднээс хамгийн бага судлажээ. Өнөө үед Баруун төвд буюу Ладакийн түүхийг харьцангуйгаар их судалсан байна. А.Каннинхэм¹, Э.Шлагинтвейт², К.Маркс³, ялангуяа "Ладакийн он дарааллын бичиг"-ийг (ᠠᠨᠤ ᠰᠢᠨᠠᠷᠠᠯᠠᠯ ᠪᠢᠴᠢᠭ) хамгийн бүрэн сайн хэвлүүлсэн бөгөөд түүхийн багавтар хэмжээний эхүүдийг нийтлүүлж, Баруун төвдийн түүхийг ерөнхийд нь судалсан А.Франке нар багагүй зүйлийг хийжээ⁴. Төвдийн эртний болон шинэ үеийн түүхийг үнэндээ маш бага судалсан ч энэ чиглэлийн ямар нэг хэмжээгээр судалгаа гарчээ. Өмнө дурдсан Э.Шлагинтвейт болон А.Франке нарын бүтээлүүд ерөнхийдөө Төвдийн түүхийг судлахад чиглэж байгаа бол А.Чома де Көрөш⁵, Сарат Чандра Дас⁶, Ф.В.Томас⁷, Л.Уодделл⁸, Е.Е.Обермиллер⁹ болон бусад судлаачид төвдийн түүхийн дурсгалыг судлах, хэвлүүлэх болон орчуулах талаар их, бага сайн, муу ямар нэг хэмжээгээр ажилласан байна. Түүнээс гадна Иакинф Бичурин¹⁰ болон хожим Башелл¹¹ нар Төвдийн эртний түүхийн холбоотой маш үнэ цэнэтэй мэдээ баримтыг хятад хэлнээс орчуулжээ. Улмаар В.Рокхилл¹² Төвдийн шинэ үед холбогдох хятад сурвалж бичгээс хэсэглэн орчуулжээ. Гэхдээ огт судлаагүй болон ашиглаагүй хэрэглэгдэхүүнтэй харьцуулбал эдгээр нийтлэл төвдийн түүхийг шүүн хэлэлцэхэд хангалтгүй юм.

Төвдийн түүхийг судлах талаар тавих хамгийн ойрын зорилт бол түүхийн эх бичгүүдийг хэвлэн нийтэлж, орчуулах явдал юм. Үүнд гол саад болж буй зүйл бол төвдийн түүхийн зохиолын хэмжээ болон төрөл анги, шинж чанарын талаар тодорхой, үнэн зөв төсөөлөл байхгүй байгаа явдал болно. Харамсалтай нь төвдийн түүхийн зохиолыг дэлхий дахины шинжлэх ухаанд бага судалсан хийгээд судалсан ч тэр бүр тийм тааламжтай бус байдлаар авч үзсэн байдгийг хүлээн

* Энд болон үүнээс хойш Төвдийг ингэж нэрлэсэн нь анх хэвлүүлсэн хянан тохиолдуулагчдын хийсэн засвар болно.

DDC
907.2
B-78

Харилцах утас: 94667144

Орос хэлнээс орчуулсан: Д.Бүрнээ
Хянан тохиолдуулсан: Д.Энхтөр

Цаасны хэмжээ: А5
Хэвлэлийн хуудас: 24хх
Хэвлэлийн газар: “Удам соёл” ХХК

ISBN 978-99973-73-09-0